



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 745

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Завхан аймагт барьж, ашиглалтад оруулсан нийт 2,289,080,000.00 (хоёр тэрбум хоёр зуун наян есөн сая наян мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга, байгууламжийг Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Даваадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201657

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
745 дугаар тогтоолын хавсралт



**Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Завхан аймгийн
Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгө**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ/төгрөг/
1	Конторын барилга	2020.10.30	1	2,288,380,000.00
2	Гадна хашаа	2020.10.30		700,000.00
	Нийт дүн			2,289,080,000.00 /хоёр тэрбум хоёр зуун наян есөн сая наян мянга/